

Year 1 Ангийн Тооны Шалгалт

Эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан мэдээлэл



Year 1 Ангийн Тооны Шалгалт гэж юу вэ?

Year 1 Ангийн Тооны Шалгалт (Year 1 Number Screening Check) нь сурагчийн тооны анхан шатны мэдлэг, чадварын ахицыг үнэлэх зорилготой, мужийн хэмжээнд зохион байгуулагддаг богино хэмжээний шалгалт юм. Уг шалгалтаар таны хүүхэд тоог таних, дараалуулан жагсаах, тоолох, харьцуулах, мөн нэмэх ба хасах үйлдлийг хэрхэн гүйцэтгэж байгааг ажиглан үнэлдэг.

Таны хүүхэд багштайгаа хамт сууж, ойролцоогоор 30 асуултад хариулах болно. Шалгалт ихэвчлэн **10-15** минут үргэлжилдэг. Year 1 Number Screening Check нь хүүхдэд дарамт үүсгэхгүй байхаар сайтар боловсруулагдсан ба хэрэв таны хүүхдэд хүндрэлтэй байвал багш шалгалтыг зогсооно.

Year 1 Number Screening Check-ийн гол зорилго нь таны хүүхдийн сургалтын төлөвлөгөөг оновчтой боловсруулахад нь багш нарт туслах зорилготой. Багш нар Year 1-ийн бүх сурагчдад энэхүү үнэлгээг хийх болно.

Хэрэв танд Year 1 Number Screening Check-ийн талаар асуух зүйл байвал сургуультай холбогдоно уу.

Тооны мэдрэмж гэж юу вэ?

Тооны мэдрэмж гэдэг нь тоог ойлгох, тоонуудыг хооронд нь холбож харьцуулах, ингэснээр тоог өдөр тутмын амьдралд үр дүнтэйгээр ашиглаж ертөнцийг ойлгох чадварыг хэлнэ. Зарим хүүхдэд тоон мэдрэмжийг эзэмших нь хүндрэлтэй байж болох тул үүнийг аль болох эрт илрүүлэх нь чухал. Ингэснээр багш тухайн хүүхдэд шаардлагатай тусгай дэмжлэгийг төлөвлөн ажиллаж чадна.

Тооны мэдрэмж яагаад чухал вэ?

Тооны мэдрэмжийн суурь мэдлэг сайн байснаар таны хүүхэд цаашид бага болон ахлах сургуульд математикийн илүү нарийн ойлголтуудыг ойлгож, эзэмшихэд тусалдаг.

Утсан орчуулгын үйлчилгээ

Хэрвээ та хүүхдийнхээ сургуультай холбогдох хүсэлтэй бөгөөд танд англи хэлний тусламж хэрэгтэй бол Утсан Орчуулгын Үйлчилгээний 131 450 дугаарт залган өөрийн ярихыг хүссэн хэлээ мэдэгдэн, сургуультай холбож өгөхийг хүсээрэй. Оператор таны яриаг орчуулах орчуулагчийг шугамд холбож өгөх болно. Уг үйлчилгээ нь үнэ төлбөргүй.